



# Open Government Partnership Independent Reporting Mechanism

## Action Plan Review: Mongolia 2023-2027 Comments Received

Comments Received from Bolormaa Battsoigt, Media Council of Mongolia, 17 July 2024

Comment on Section II: Commitment 4
<p>Хуулийн болон бусад арга зам гэдгийг, "Хуулийн болон өөрийн зохицуулалтын механизмыг" ашиглан гэж өөрчлөх.</p> <p>Хэвлэл мэдээллийн эрх чөлөөг хамгаалахад хуулийн арга замаас илүү өөрийн зохицуулалтын арга замыг сонгохыг НҮБ-ээс зөвлөдөг ба энэ зөвлөмжид үндэслэвэл "Өөрийн зохицуулалтын болон хуулийн арга замыг" гэж өөрийн Өөрийн зохицуулалтын механизмыг урд нь оруулах нь зүйтэй.</p> <p><a href="https://unesdoc.unesco.org/ark:/48223/pf0000191624">https://unesdoc.unesco.org/ark:/48223/pf0000191624</a> <a href="https://unesdoc.unesco.org/ark:/48223/pf0000383832">https://unesdoc.unesco.org/ark:/48223/pf0000383832</a></p>
<p>албадан барвчлах гэдэг нь хэт нарийн утгатай болох ба нэр төр алдар хүндтэй холбоотой заалтуудыг эрүүгийн хуулиас авах гэж өөрчлөх.</p> <p>Эрүүгийн хуулийн 13.14-д доорх заалт байгаа нөхцөлд Хэвлэл Мэдээллийн талаарх шинэ хуульд үүнтэй зөрчилдөх заалт орох боломжгүй учир. Энэ заалтыг авах гэж оруулах</p> <p>Эрүүгийн хууль 13.14. Худал мэдээлэл тараах</p> <p>Хүний нэр төр, алдар хүнд, хуулийн этгээдийн ажил хэргийн нэр хүндэд халдсан илт худал мэдээллийг олон нийтэд тараасан бол дөрвөн зуун тавин нэгжээс нэг мянга гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас гурван сар хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ.</p>
<p>Өмчлөлийн хэт төвлөрлийн асуудлын талаар дахин сайн бичих шаардлагатай харагдаж байна. Хэвлэлийн хүрээлэнгийн судалгаа нь олон жилийн өмнөх судалгаа ба одоо харин ч задрал явагдаж байгаа.</p> <p>Онолын хувьд eliminating mass media concentration гээд босоо төвлөрөл болон хэвтээ төвлөрөл гэх мэт нарийн ухагдахуунууд явдаг тул энэ талаар тодорхой оруулж байж хуулийн өөрчлөлтийн хэрэг нь гарна. Ард эзэн хэн бэ гээд ил тод болголоо гээд ямар ч асуудал шийдвэрлэгдэхгүй. Иймээс энэ хэсгийг дахин сайжруулах шаардлагатай харагдаж байна.</p>
<p>Хэвлэл мэдээллийн ёс зүйн зүрмийг шинэчлэж байгаа ба энэ үйл ажиллагаанд энд дурдсан бүх талууд оролцож байгаа билээ. Энэ хэсэгт дахин өөрчлөн найруулан бичих шаардлагатай.</p>
<p>ёс зүйг даган мөрдөхийг шаардах тулгах бол ёс зүй биш хууль болох учир энэ</p>

хэсэг ямар ч шаардлагагүй. Сэтгүүлч мэргэжил нь өөрөө үнэмлэхтэй хийдэг эмч өмгөөлөгч шиг мэргэжил биш ёс зүйтэй сэтгүүлч гэж үнэмлэх өгөх гэж угаасаа боломжгүй. Харин тийм ёс зүйтэй сэтгүүлчийг хүлээн зөвшөөрдөг, буруу бичсэнг нийгэм өөрөө шүүдэг тийм соёлтой болгохын тулд төрийн дэмжлэг хэрэгтэй.